



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА  
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 4/181

Улаанбаатар хот

Г Органик бүтээгдэхүүн/Certified organic  
эко шошго хэрэглэх эрх олгох журам батлах тухай

МҮХАҮТ-ын дүрмийн 10.6 дугаар заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Байгалийн нөөцийг хэмнэсэн, экосистемийн үйлчилгээг тэтгэсэн, хүлэмжийн хийн ялгарал, алдагдал, хаягдал багатай, байгаль орчныг бохирдол, доройтлоос сэргийлсэн, байгальд ээлтэй үйлдвэрлэлийн аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг баталгаажуулах зорилгоор “Органик бүтээгдэхүүн/Certified organic эко шошго хэрэглэх эрх олгох журам”-ыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. Тус журмыг тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллахыг Бодлого судалгаа хөгжлийн газар /М.Хосбаяр, Б.Оюунбат/-т, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого судалгаа хөгжлийн газар /Ж.Оюунчимэг/-т даалгасугай даалгасугай.

Гурав. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан 2014 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 180 тоот тушаал /Хавсралт -1“Органик бүтээгдэхүүн/Certified organic эко шошго хэрэглэх эрх олгох журам”/-ыг хүчингүйд тооцсугай.

Дөрөв. “Органик бүтээгдэхүүн/Certified organic эко шошго хэрэглэх эрх олгох журам”-ыг 2018 оны 11 сарын 02-ны өдрөөс дагаж мөрдсүгэй.

Тав. Тушаалыг ажилтнуудад танилцуулахыг Үйл ажиллагаа, зохицуулалтын газар /Б.Мөнхзул/-т даалгасугай.

ДАРГА

Оюунчимэг

М.ОЮУНЧИМЭГ

0000747

МУХАЙТ-ЫН ДАРГЫН 2018 ОНЫ 10 дугаар  
САРЫН 20. ЕДРИЙН 11ЛТООТ ТУШААЛЫН  
1 ДУГЭЭР ХАВСРАЛТ

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

БҮТЭЭГДЭХҮҮНД “ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮН/CERTIFIED ORGANIC”  
ЭКО ШОШГО ХЭРЭГЛЭХ ЭРХ ОЛГОХ ЖУРАМ

БАТАЛГААЖИЛТ:

	Овог нэр	Албан тушаал	Огноо	Гарын усэг
Боловсруулсан:	М.Хосбаяр Б.Оюунбат	БСХГ-ын мэргэжилтэн БСХГ-ын мэргэжилтэн	2018.10.23 2018-10-23	М.Хосбаяр Б.Оюунбат
Хянасан:	Ж.Оюунчимэг	БСХГ-ын дарга дарга	2018.10.25	Ж.Оюунчимэг
Зөвшөөрсөн:	М.Сарандаваа	Орлогч дарга	2018.10.25	М.Сарандаваа
Баталсан:	М.Оюунчимэг	Дарга	2018.10.25	М.Оюунчимэг

## АГУУЛГА

1. Нийтлэг зүйл .....	4
2. Органик үйлдвэрлэлийн зорилго.....	4
3. Органик үйлдвэрлэлийн үндсэн зарчим .....	4
4. Шалгуур үзүүлэлт .....	5
5. Хүсэлт гаргах .....	5
6. Эко шошгыг хэрэглэх эрх олгох .....	6
7. Хугацааг сунгах .....	6
8. Цуцлах .....	6
9. Хураамж .....	6
10. Эко шошго хэрэглэх .....	7
11. Сурталчилгаа, дэмжлэг үзүүлэх .....	7

Хавсралтууд:

- Хавсралт 1: Органик мал аж ахуйн шалгуур үзүүлэлт
- Хавсралт 2: Органик газар тариалангийн шалгуур үзүүлэлт
- Хавсралт 3: Органик зөгийн аж ахуйн шалгуур үзүүлэлт
- Хавсралт 4: "Органик бүтээгдэхүүн/Certified organic" гэрчилгээний загвар
- Хавсралт 5: Гэрээний загвар
- Хавсралт 6: Шошго авсан бүтээгдэхүүний жагсаалт
- Хавсралт 7: Багийн гишүүдийн жагсаалт

## 1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

- 1.1 Байгалийн нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай ашигласан, экосистемийн үйлчилгээг тэтгэсэн, хүлэмжийн хийн ялгарал болон алдагдал, хаягдал багатай, байгаль орчны бохирдол доройтлоос сэргийлсэн буюу байгальд ээлтэй үйлдвэрлэлийн аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг баталгаажуулахад энэхүү журмыг баримтална.
- 1.2 "Органик бүтээгдэхүүн/Certified organic" эко шошго нь тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, боловсруулж буй аж ахуйн нэгж нь тогтвортой, органик хөдөө аж ахуйн гаралтай, хүнсний бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж буйг гэрчлэх тэмдэг болно.
- 1.3 Тухайн байгууллагын гаргасан хүсэлтийн дагуу, сайн дурын үндсэн дээр "Органик бүтээгдэхүүн/Certified organic" эко шошгыг олгоно.

## 2. ОРГАНИК ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЗОРИЛГО

Органик үйлдвэрлэлд дараах зорилгуудыг дагаж мөрдөнө.

### 2.1. ХАА-н тогтвортой менежментийн тогтолцоог бий болгох. Үүнд:

- 2.1.1 Эко системийн тогтолцоо, амьдралын мөчлөгийг хадгалах, хөрс, ус, ургамал, мал амьтдын эрүүл байдал, тэдгээрийн хоорондын тэнцлийг хангах
- 2.1.2 Биологийн олон янз байдлыг доройтуулахгүй байх, сайжруулахад хувь нэмэр оруулах
- 2.1.3 Эрчим хүч болон ус, агаар, органик бодис зэрэг байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах
- 2.1.4 Мал, амьтдын амьдрах таатай, ялангуяа төрөл зүйл бүрийн зан байдлын шаардлагад нийцсэн орчинг бүрдүүлэх

### 2.2 Сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэх

### 2.3 Байгаль орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд, ажлын байр болон ургамал, мал амьтан мөрөг нөлөөгүй технологиор боловсруулсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг хангах

## 3. ОРГАНИК ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ

### 3.1 Эко системүүдэд түшиглэсэн, байгалийн нөөцийг ашигласан биологийн холбогдох процессын дараах дизайн, менежментийг хэрэгжүүлэхэд баримталах ерөнхий зарчим

- 3.1.1 Амьд организм ба механик үйлдвэрлэлийн аргуудыг хэрэглэх
- 3.1.2 Газар шороонд тулгуурласан тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, тогтвортой загасны аж ахуй эрхлэх
- 3.1.3 Хувиргасан амьд организмууд, мал эмнэлгийн зориулалттайгаас бусад тэдгээрээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэрэглэхгүй байх
- 3.1.4 Эрсдэлийн үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

### 3.2 Гадны нэмэлтүүдийг хязгаарлах зарчим баримтална

Гадны нэмэлтүүд шаардлагатай бол зөвхөн дараах нэмэлтүүдийг хэрэглэж болно. Үүнд:

- 3.2.1 Органик үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн
- 3.2.2 Байгалийн буюу тэдгээрийн хоёрдогч бодисууд
- 3.2.3 Сул уусдаг эрдэс бордоо

#### 4. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Органик бүтээгдэхүүнд тавигдах шалгуур нь Органик мал аж ахуй, Органик газар тариалан, Органик зэгийн аж ахуйн шалгуур үзүүлэлтүүдээс бүрдэнэ. Органик бүтээгдэхүүнд тавигдах шалгуур үзүүлэлтүүдийг хавсралт шалгуураар батлана.

- 4.1 Органик мал аж ахуйн шалгуур үзүүлэлт (Хавсралт 1)-р
- 4.2 Органик газар тариалангийн шалгуур үзүүлэлт (Хавсралт 2)-р
- 4.3 Органик зэгийн аж ахуйн шалгуур үзүүлэлт (Хавсралт 3)-р
- 4.4 “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошго хэрэглэх гэрчилгээг (Хавсралт 4) олгоно.

#### 5. ХҮСЭЛТ ГАРГАХ

5.1 Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошго хэрэглэх эрх авахыг хүссэн аж ахуйн нэгж нь дараах материалыг бүрдүүлж MYXAYT ирүүлнэ. Үүнд:

- 5.1.1 Шошго хэрэглэхийг хүссэн өргөдөл
- 5.1.2 Тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь Органик үйлдвэрлэлийн зорилго, зарчмуудад нийцэж байгаа тухай тодорхойлолт
- 5.1.3 Тухайн бүтээгдэхүүн тухайн төрлийн органик бүтээгдэхүүнд тавигдах Хавсралтад заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангаж байгаа тухай тодорхойлолт
- 5.1.4 Технологийн бүдүүвч зураг
- 5.1.5 Бүтээгдэхүүн нь холбогдох стандартын шаардлагыг хангаж байгаа тухай эрх бүхий лабораторуудын хийсэн шинжилгээний дүгнэлт
- 5.1.6 Бүтээгдэхүүн, үйлчилгээ нь байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн заалтуудад нийцэж байгааг баталгаажуулсан холбогдох мэргэжлийн байгууллагуудын тодорхойлолт (байгаль орчны ерөнхий/нарийвчилсан үнэлгээний дүгнэлт)
- 5.1.7 Байгууллагын гэрчилгээний хуулбар/иргэний үнэмлэхийн хуулбар, шаардлагатай бол холбогдох тусгай зөвшөөрлийн хуулбар

## 6. ЭКО ШОШГЫГ ХЭРЭГЛЭХ ЭРХ ОЛГОХ

- 6.1 Хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор MYXAYT-ын холбогдох мэргэжилтнүүд болон тухайн салбарын төлөөлөгчдөөс бүрдсэн баг газар дээр нь үнэлгээ хийнэ.
- 6.2 Шаардлагатай гэж үзвэл баримтуудыг дахин үнэлүүлэхээр холбогдох газруудад шилжүүлж өргөдөл гаргагчид буцааж болно.
- 6.3 “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошго хэрэглэх хугацаанд бүтээгдэхүүний орцод өөрчлөлт, нэмэлт оруулахгүй байх, орц найрлагыг өөрчлөхөөр бол MYXAYT-д мэдээлнэ.
- 6.4 MYXAYT-ын холбогдох мэргэжилтнүүд болон тухайн салбарын төлөөлөгчид холбогдох шалгууруудыг хангасан байдлыг үндэслэн “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошго хэрэглэх эрхийг баталгаажуулна.
- 6.5 Багийн гишүүдийн шийдвэрийг үндэслэн MYXAYT-аас гэрчилгээ олгож, гэрээ байгуулна.
- 6.6 “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошго хэрэглэх эрх нь 2 жилийн хугацаатай байна.
- 6.6 Багийн гишүүд нь энэхүү журмын 6.1 заасан төлөөлөгчдөөс бүрдэнэ. (Хавсралт 7)-р батална.

## 7. ХУГАЦААГ СУНГАХ

- 7.1 Бүтээгдэхүүн нь холбогдох шалгууруудыг хангасан, гэрээний шаардлагад нийцсэн хэвээр байвал “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шоштыг хэрэглэх хугацааг дахин 2 жилийн хугацаагаар сунгана.
- 7.2 Тухайн аж ахуйн нэгж нь “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошгыг хэрэглэх гэрээний хугацаа дуусахаас хамгийн багадаа 2 сарын өмнө гэрээг дахин сунгах хүсэлтээ өргөдлөөр гаргана.

## 8. ЦҮЦЛАХ

- 8.1 MYXAYT-ын холбогдох мэргэжилтнүүд болон тухайн салбарын төлөөлөгчдийн багаас тухайн аж ахуйн нэгжид хийсэн шалгалт, дүгнэлтийг үндэслэн шошго хэрэглэх эрхийг цуцалж, бүртгэлээс хассан тохиолдолд “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошго хэрэглэх эрх цуцлагдана.

## 9. ХУРААМЖ

- 9.1 “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошго авч байгаа аж ахуйн нэгжүүд эрх авах болон жилийн хураамж төлнө.

Эрх олгох хураамж, ₮	Жилийн хураамж, ₮
200.000	500.000

- 9.2 Хураамж нь хяналт шалгалт хийх, зар сурталчилгаа хийх, экспертийн зөвлөгөө өгөх, үзэсгэлэн яармаг зохион байгуулах зэрэг 6-р зүйлд заасан тогтвортой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлуудад зарцуулагдана.

9.3 Эрх авахаар хүсэлт гаргасан аж ахуйн нэгж нь “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошго хэрэглэх шийдвэр гарснаар хураамж төлнө.

## 10. ЭКО ШОШГО ХЭРЭГЛЭХ

10.1 Гэрээ нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг тодорхойлох ба “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошго бүхий бүтээгдэхүүнийг сурталчлах, хэрэглэгчдийг төөрөгдүүлэхээс зайлсхийх, бусад нөхцөлүүдийг тодорхойлсон байна.

10.2 “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошго хэрэглэх эрх авсан байгууллага цаашид үйл ажиллагаагаа тогтвортжуулах, боловсронгуй болгох төлөвлөгөө гаргаж ажиллана.

10.3 “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошго хэрэглэх эрх авсан байгууллага MYXAYT-тай (Хавсралт 5) гэрээ байгуулна.

10.4 Шошго хэрэглэх эрх авсан аж ахуйн нэгжүүдийн бүртгэлийг цахимаар болон цаасаар баталгаажуулан хадгална. (Хавсралт 6)

## 11. СУРТАЛЧИЛГАА, ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

10.1 “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошгыг хэрэглэх боломжууд:

- 11.1.1 Бүтээгдэхүүний шошго, танилцуулга, каталог, интернет хаяг, аж ахуйн нэгжийн болон сурталчилгааны танилцуулга дээр тухайн бүтээгдэхүүний зураг, тодорхойлолтын хамт байршуулах
- 11.1.2 Байгууллага, худалдааны төвийн үүдэнд тухайн бүтээгдэхүүний зураг, тодорхойлолтын хамт байршуулах, сурталчлах /наах, хавчих, танилцуулга хэлбэрээр/
- 11.1.3 Үзэсгэлэн, яармагийн үеэр тухайн бүтээгдэхүүний зураг, тодорхойлолтын хамт ашиглах

11.2 Дээрх үйл ажиллагаанд зөвхөн “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошго хэрэглэх эрх авсан бүтээгдэхүүнийг сурталчлах ба аж ахуйн нэгжийг сурталчлах зорилгоор ашиглахыг хориглоно.

11.3 MYXAYT нь дараах арга хэрэгслээр “Органик бүтээгдэхүүн/Certified organic” эко шошго хэрэглэх эрх авсан байгууллагуудын үйл ажиллагааг сурталчилна. Үүнд:

- 11.3.1 Төрийн холбогдох байгууллагууд, ШУА-ийн хүрээлэнгүүд, олон нийтийн байгууллагууд, бизнес эрхлэгчидтэй хамтран олон улсын ба дотоодын үзэсгэлэн яармагт хамруулна.
- 11.3.2 Танхимын вэб сайт, эрхлэн гаргадаг “Бизнес таймс” сонин, “Бизнес ба хөгжил” сэтгүүл, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр сурталчилна.

11.4 Байгаль орчинд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээний сургалт, зөвлөгөөгөөр хангана.

11.5 Бичил зээлийн Органик монгол хөтөлбөрт хамруулах үйл ажиллагааг дэмжинэ.



## ОРГАНИК МАЛ АЖ АХУЙД ТАВИХ ШАЛГУУРУУД

### ШАЛГУУР 1. МАЛ АЖ АХУЙН МЕНЕЖМЕНТ

#### Үндсэн зарчим

Органик мал аж ахуй нь газар, ургамал, мал амьтан гурвын зохицдолт байдлыг эрхэмлэсэн, малын физиологи, амьдрах байдлын хэрэгцээ ба органик гаралтай сайн чанарын хоолоор хангах шаардлагад нийцсэн байна.

#### Зөвлөмж

Органик мал аж ахуй эрхлэгч нь:

- а. Малыг органик гаралтай сайн чанарын хоолоор хангана.
- б. Малын байгалийн төрөлх зан чанарт нийцэх, байгалийн нөөц, орчны чанарыг хадгалах хэмжээний тоо толгой, төл, том малтай байна.
- в. Малыг зовиургүй, эрүүл, сайн сайхан байлгах, өвчлөл, халдвараас сэргийлэх арга хэмжээ авах ба химиин гаралтай мал эмнэлгийн эмчилгээний бодис хэрэглэхгүй байна.
- г. Газар ба усыг тогтвортой ашиглах менежмент нэвтрүүлнэ.

#### Шаардлага

1. Мал аж ахуй эрхлэгч нь доорх үүргийг хүлээнэ:

Мал аж ахуй эрхлэгч нь малын төрөлх зан чанарт нийцэхүйц орчин, байр, сүргийн нягтрал, төл ба том малын харьцааг хангах ба доорх шаардлагыг хангасан байна:

- 1.1 Мал чөлөөтэй хөдөлж харайх, зан байдлаа илэрхийлэх боломжтой байх
- 1.2 Хангалттай цэвэр агаар, ус, хоол тэжээл, байгалийн гэрэлтүүлгээр хангах
- 1.3 Зовиургүй байлгах зорилгоор хэвтэж амрах, нарны гэрэл, халуун, бороо, бохирдол, салхинаас халхлах хашаа саравчаар хангах
- 1.4 Ижил зүйлийн сүргийг хооронд нь тусгаарлахгүй байх
- 1.5 Хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй барилгын материал, үйлдвэрлэлийн төхөөрөмж хэрэглэх

Энэ шаардлага нь хувийн үйлдвэрлэлийн жижиг сүрэгт хамаарахгүй. Хувийн жижиг мал аж ахуй эрхлэгч нь эр, өвчтэй, төллөх мал амьтдыг тусгаарлаж болно.

2. Хашаа саравч, орон байр нь дараах шаардлагыг хангасан байна:

- 2.1 Цэвэр ус, хоол тэжээлээр хангах боломжтой
- 2.2 Амьтад хэвтэх, эргэж хөрвөх, өөрсдийгөө арчлах, суниах, далавчаа дэвэх гэх мэт байгалийн хөдөлгөөн хийх хангалттай орон зайдай
- 2.3 Малын хэвтэргэтийн байгалийн гаралтай материал ашигласан мал сүргийн эрүүл мэндэд сөрөг нөлөөл үзүүлэхээргүй агаар сэлгэлт, тоосжилт, чийгшилт, хийн түвшинг хангасан тусгаарлалт, халаалт, агааржуулалт, сэргүүцүүлэг бүхий
- 2.4 Шувуу, туулай, гахайг торонд хийхгүй
- 2.5 Зэрлэг, зэрлэгшсэн амьтдын халдлагаас хамгаалагдсан.

3. Газаргүй мал аж ахуй байж болохгүй.
4. Бүх амьтад физиологийн байдал, таатай нөхцөл, газрын хэлбэр байдлаас үл хамааран бэлчээр, задгай газарт чөлөөтэй бэлчих боломжтой байна.

Цаг агаарын таагүй нөхцөлд, эсвэл улирлаас үүдэлтэй тэжээлийн хомсдол үүсэхэд амьтдыг тусгаарлаж болно. Гэхдээ тэдгээр амьтдыг мөн задгай газар гаргаж байх

ба бэлчээрт гаргахгүйгээр тэжээж болно. Амьтдын амьдрах таатай орчинг муутгаж болохгүй.

5. Гэрэлтэй байх хугацааг уртасгах зорилгоор цахилгаан гэрлийг мал амьтны байгалийн зан байдал, эрүүл мэндэд нөлөөлөхүйц урт хугацаагаар ашиглахыг хориглоно.

## ШАЛГУУР 2. ШИЛЖИЛТИЙН ҮЕ

Үндсэн зарчим

Органик мал аж ахуйд шилжихэд завсрын буюу шилжилтийн үе шаардагдана.

Зөвлөмж

Органик аж ахуйн бүх мал амьтад органик байх ёстой.

Шувууг солиходо органик аж ахуйд шилжихийн өмнө хийсэн байна.

Шаардлага

1. Газар ба мал амьтад нь тогтоосон шилжилтийн үеийн шаардлагуудыг бүрэн хангасны дараах махан бүтээгдэхүүнийг "органик хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн"-д тооцно.
2. Газар ба мал амьтдыг органик аж ахуйн шаардлагад шилжүүлэх үйл ажиллагааг тогтоосон шаардлагын дагуу нэгэн зэрэг хийнэ.
3. Мал, амьтдыг органик аж ахуйн шаардлагад шилжүүлэхэд шаардагдах хамгийн бага шилжилтийн хугацааг дараах хүснэгтээр тооцно.

Бүтээгдэхүүн	Шилжилтийн үе
Max	12 сар
Сүүн бүтээгдэхүүн	90 хоног
Өндөг	42 хоног

## ШАЛГУУР 3. АМЬТНЫ ГАРАЛ ҮҮСЭЛ

Үндсэн зарчим

Органик мал, амьтад нь органик аж ахуйд төрж, өссөн байна.

Зөвлөмж

Органик мал аж ахуй нь уламжлалт бойжуулах аргаас хамаарах ёсгүй.

Органик аж ахуйн гаднаас авчирсан мал, амьтад нь органик аж ахуйгаас буюу мал, амьтны эрүүл мэнд, чанарыг сайжруулах хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж буй тусгай аж ахуйгаас авчирсан байна.

Шаардлага

1. Мал, амьтдыг төрөхөөс эхлэн органик байдлаар өсгөнө.
  2. Органик мал, амьтад байхгүй бол дараах насны мал, амьтдыг органик бус аж ахуйгаас авч болно:
    - 2.1 1 хоногтой дэгдээхэйг махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор
    - 2.2 1 жил 6 сартай эм тахиаг өндөгний үйлдвэрлэлд
    - 2.3 14 хоногтой бусад төрлийн шувууд
    - 2.4 42 хоногтой, сүүнээсээ гарсан тооройнууд
    - 2.5 4 долоо хоногтой, уургаа хөхсен, голчлон сүүгээр тэжээсэн тугалыг саалийн зориулалтаар
  3. Үржүүлгийн мал, амьтныг авахдаа тухайн жилийн тухайн төрлийн том малын 10%-иас ихгүйгээр уламжлалт мал аж ахуйгаас авч болно.
- Зөвхөн дараах тохиолдолд дээрх хэмжээнээс илүү авахыг зөвшөөрнө:

1. урьдаас төсөөлөөгүй хахир хүйтэн цаг агаар ба хүний үйл ажиллагаа
2. аж ахуйг их хэмжээгээр өсгөх болсон
3. өөр төрлийн мал, амьтан үргүүлэх
4. аж ахуй 10-аас цөөн тооны мал, амьтантай байх

#### ШАЛГУУР 4. ҮҮЛДЭР БА ҮРЖҮҮЛЭГ

Үндсэн зарчим

Мал, амьтны үүлдэр нь тухайн орон нутгийн нөхцөл байдалд дасан зохицсон байна.

Зөвлөмж

Мал, амьтан үргүүлгийн зорилго нь тэдгээрийн эрүүл мэнд, чанарыг хамгаалах чиглэсэн, байгалиас заясан зан чанартай нь нийцсэн байвал зохино.

Үржүүлгийн үйл ажиллагаанд мал, амьтны байгалийн зан чанарыг түрэмгийлэх өндөр технологоос хамааралтай ба хөрөнгө их шаардсан арга хэрэгслийг ашиглаж болохгүй.

Мал, амьтныг тэдгээрийн байгалийн үржлийн аргаар үргүүлнэ.

Шаардлага

1. Үржүүлгийн тогтолцоо нь хүний оролцоогүйгээр, байгалийн нөхцөлд үржих чадвартай үүлдээр тулгуурлана.
2. Зохиомол хээлтүүлгийг зөвшөөрнө.
3. Үр шилжүүлэн суулгах, эсээр үргүүлэхийг хориглоно.
4. Даавраар овуляци хийх, төрөлтийг өдөөхийг хориглох боловч эмчилгээний зориулалтаар буюу мал эмнэлгийн хяналтан доор даавар хэрэглэж болно.

#### ШАЛГУУР 5. ГАДААД БАЙДЛЫГ ӨӨРЧЛӨХ, ГЭМТЭЭХ

Үндсэн зарчим

Органик аж ахуйд мал, амьтны өвөрмөц шинж байдлыг хүлээн зөвшөөрнө.

Зөвлөмж

Органик мал аж ахуйд гадаад байдлыг өөрчлөх, гэмтээх, шаардлагагүй мал, амьтны төрөл зүйлийг сонгож үргүүлнэ.

Зөвхөн мал, амьтны эрүүл мэнд, өвчин шаналлыг багасгах зорилгоор мэс заслын аргаар эмчилгээ хийж болно.

Шаардлага

Мал, амьтныг хамгийн бага зовоож шаналгах байдлаар, эсвэл мэдээ алдуулагч бодис хэрэглэж доорх арга хэмжээг авч болно. Үүнд:

1. хөнгөлөх буюу засах
2. хурганы сүүл тайрах
3. звэр тайрах
4. бөгжклөх
5. өтөхөөс сэргийлж хонины сүүл хэсгийн арьсны хуниасыг тасдаж авах

#### ШАЛГУУР 6. МАЛ АМЬТНЫ ТЭЖЭЭЛ

Үндсэн зарчим

Органик мал, амьтад нь органик тэжээл, сайн чанарын бэлчээрээр хооллоно.

Зөвлөмж

1. Мал, амьтны хоол тэжээл нь тэдгээрийн хэрэгцээг бүрэн хангасан, байгалийн хооллолт, хоол боловсруулах шинж чанарт нийцсэн байна.
2. Хивдэг амьтдад тэдгээрийн онцлог шаардлагад нийцсэн хоол тэжээл өгөх ба зөвхөн даршны ургамал, өтгөрүүлсэн тэжээл өгч болохгүй.
3. Органик мал, амьтдыг органик хүнс боловсруулдаг үйлдвэрийн дайвар бүтээгдэхүүнээр хооллож болно.
4. Бүх хоол тэжээлийг тухайн ферм дээр, эсвэл тухайн бус нутагт үйлдвэрлэсэн байвал зохино.
5. Органик мал аж ахуйд тэжээлд өнгө оруулагч хэрэглэж болохгүй.

#### Шаардлага

1. Органик мал амьтныг органик хоол тэжээлээр хооллоно.
2. Органик аж ахуйд дараах тохиолдолд тусгай нөхцөлөөр, тодорхой хугацаанд, хязгаартай хэмжээгээр органик бус тэжээл ашиглахыг зөвшөөрнө. Үүнд:
  - a. органик тэжээл нь тоон хэмжээ, чанарын шаардлага хангахгүй байгаа
  - b. хөгжлийн эхэн үедээ явж буй органик ХАА-н бус нутгуудад

Ямар ч тохиолдолд органик бус тэжээлийн хэмжээ хивдэг амьтдын хувьд 1 жилд ноогдох тэжээлийн хуурай бодисын агууламжаас 10%-аас ихгүй, хивдэггүй амьтдын хувьд 15%-аас ихгүй байх шаардлагатай.

3. Малын тэжээлийн 50-иас доошгүй хувь нь тухайн органик аж ахуйгаас, эсвэл тухайн бусийн өөр органик аж ахуйгаас гаралтай байна.
4. Тухайн аж ахуйд төрсөн малыг тэжээхэд тухайн органик аж ахуйгаас эхний жилд авсан хоол тэжээлийг органик гэж үзнэ.
5. Дараах бодисуудыг хоол тэжээлд ашиглахыг хориглоно:
  - 5.1 ХАА-н мал амьтны дайвар бүтээгдэхүүнийг (жишээлбэл, нядалгааны хаягдал) хивдэг амьтдад өгөх
  - 5.2 нэг ижил төрлийн амьтны нядалгаанаас гарах бүтээгдэхүүн
  - 5.3 шүлс, сангас, баас зэрэг малын бүх төрлийн ялгадас
  - 5.4 уусмылыг хандлах аргаар (жишээ нь, гексан), эсвэл бусад химийн бодисуудыг нэмж гаргаж авсан тэжээл
  - 5.5 амин хүчлийн изолятууд
  - 5.6 шээсний хүчил (шивтэр), бусад нийлэг азотын нэгдлүүд
  - 5.7 өсөлт идэвхжүүлэх, сэргээх нийлмэл бодисууд
  - 5.8 нийлэг амт оруулагч
  - 5.9 байгалийн бус өнгө оруулагч
  - 5.10 хамгаалах бодисууд
6. Мал амьтдыг витамин, микроэлемент, байгалийн нэмэлт зэргээр хооллож болно. Хэрвээ байгалийн нэмэлтүүдийн олдоц ховор, чанар муу байвал хиймэл витамин, эрдэс, нэмэлт зэргийг ашиглаж болно.
7. Бүх төрлийн хивдэг мал амьтдыг өдөр тутам хивгээр хооллоно.
8. Дараах хамгаалах бүтээгдэхүүнийг тэжээлд хэрэглэж болно:
  - 8.1 бактери, мөөг/ мөөгөнцөр, энзимүүд
  - 8.2 хүнсний үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн (жишээ нь, бурам)
  - 8.3 ургамлын гаралтай бүтээгдэхүүн
9. Сүүн тэжээлтэй мал, амьтдын үр төлийг эхийнх нь сүүгээр, аль эсвэл ижил төрлийн

Нийлмэл цууны хүчил, шоргоолжны хүчил, пропины хүчил, витамин, эрдэс зэрэг химийн консервантуудыг хахир хүйтэн уур амьсгалтай үед хэрэглэхийг зөвшөөрнө.

амьтны органик сүүгээр хооллох ба тухайн амьтны байгалийн зан чанарыг тооцсоны үндсэн дээр эхээс нь тусгаарлана (хөхнөөс гаргана).

Органик сүү байхгүй тохиолдолд органик бус сүү хэрэглэж болно.  
Органик мал аж ахуй эрхлэгч нь онцгой тохиолдолд ямар нэг антибиотик, хиймэл нэмэлт, нядалгааны бүтээгдэхүүний орцгүй сүү орлуулагч хэрэглэж болно.

## ШАЛГУУР 7. МАЛ ЭМНЭЛЭГ/ ЭМЧИЛГЭЭ

### Үндсэн зарчим

Органик мал аж ахуй нь органик тэжээл, ая таатай орчин ба өвчин, паразит, халдварт өвчиний эсрэг үржүүлгийн арга хэрэгслээр эрүүл, чанартай мал амьтдыг дэмжин хөгжүүлдэг.

### Зөвлөмж

1. Органик мал аж ахуй эрхлэгч нь мал амьтдын эрүүл мэндийг хамгаалах, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дараах аргуудыг ашиглана.
  - 1.1 тохирох удам, үүлдэл угсааг сонгон үржүүлэх
  - 1.2 тухайн мал, амьтны төрөл зүйлд тохирсон (хөдөлгөөний ба бэлчих дадлага, байгалийн дархлаа, өвчин эсэргүүцэх чадварыг сайжруулах г.м) практик нэвтрүүлэх.
  - 1.3 сайн чанарын органик тэжээлээр хангах
  - 1.4 тоо толгойн тохирох зөв нягтшилыг хангах
  - 1.5 бэлчээр сэлгэлтийн менежментийг зөв хийх

Органик мал аж ахуй эрхлэгч нь зугуухан эмчилгээ, аюурведийн эмчилгээ, зүү тавих зэргийг оролцуулан байгалийн эм, эмчилгээний аргуудыг ашиглах нь зүйтэй.

Өвчин илэрсэн тохиолдолд өвчний шалтгааныг тогтоож, цаашдын өвчний тархацаас сэргийлэх холбогдох арга хэмжээг авах ёстай.

### Шаардлага

1. Органик мал аж ахуй эрхлэгч нь мал аж ахуйн урьдчилсан сэргийлэх менежментийг хэрэгжүүлэх арга замаар мал амьтны эрүүл мэнд, ая таатай байдлыг хангах ёстай.
2. Хэдийгээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан боловч мал амьтан гэмтэж бэртсэн, өвчилсөн бол зохих арга хэмжээг яаралтай авч, шаардлагатай бол тохирох орон байранд тусгаарлана. Энэ тохиолдод мал амьтны зовиурыг арилгахын тулд органик статусаа алдах эрсдэлтэй байсан ч эм тарианаас татгалзахгүй байх шаардлагатай.

Химиин аллопатик мал эмнэлгийн бэлдмэл, антибиотикийг зөвхөн дараах тохиролдолд хэрэглэж болно:

- урьдчилан сэргийлэх ба өөр бусад аргууд нь мал амьтдын гэмтэл бэртлийг эмчлэхэд идэвхитэй нөлөөлөхгүй байгаа.
  - малын эмчийн хяналтан доор хэрэглэх
  - эмчилгээнд хэрэглэсэн эм бэлдмэлийн гадагшлах хугацаа хуульд зааснаас хоёр дахин ихээс багагүй, эсвэл хамгийн багадаа 48 цаг байна.
3. Үйлдвэрлэлийг дэмжих, эсвэл байгалийн өсөлтийг дарангуйлах хиймэл бодис хэрэглэхийг хориглоно.
  4. Вакцинжуулалтыг дараах хязгаарлалтын дагуу хийнэ:
    - орон нутагт тархсан өвчин нь тухайн аж ахуйн оршин буй бус нутагт асуудал үүсгэсэн/үүсгэх нь тодорхой болсон, менежментийн өөр бусад аргаар

- шийдвэрлэх боломжгүй
- хуулийн дагуу вакцинжуулах шаардлагатай
  - вакциныг генетикийн аргаар гаргаж аваагүй бол

#### ШАЛГУУР 8. ТЭЭВЭРЛЭЛТ, НЯДАЛГАА

Үндсэн зарчим

Органик мал амьтныг тээвэрлэх, нядлах үед зовиургүй байлгана.

Зөвлөмж

Мал амьтанг хамгийн бага давтамжтайгаар, боломжтой зайнд тээвэрлэнэ.

Амьтдыг тээвэрлэлтийн үед тогтмол шалгана.

Тээврийн хэрэгсэл нь тухайн амьтанд тохирсон байна.

Мал амьтдыг цаг агаар, тээвэрлэлтийн нөхцлөөс хамаарч усалж, хооллоно.

Тээвэрлэлт, нядалгаа хийх үед мал амьтны зовиурыг багасгах зорилгоор дараах арга хэмжээг авна:

1. хангалттай амрах хугацаа олгох
2. ижил сүрэг, орчинг хадгалах
3. амьд мал амьтад үхсэн, нядалгаанд орж буй мал амьтадтай харьцахаас (үнэрлэх, харах, сонсох) сэргийлэх Малыг цуслахын өмнө заавал дүйрүүлнэ. Уламжлалт ёс жаншлын дагуу нядалж болно.

Боломжтой тохиолдолд орон нутгийн болон нүүдлийн нядалгааг ашиглаж болно.

Шаардлага

1. Тээвэрлэх, нядлах үед мал амьтадтай анхаарал болгоомжтой, тайван хандана.
2. Цахилгаан бороохой гэх мэт багаж ашиглахыг хориглоно.
3. Тээвэрлэлт, нядалгааны мал амьтдад үзүүлэх серөг нөлөөллийг багасгах, хамгийн бага хэмжээнд бууруулах нөхцөл байдлыг хангана. Үүнд:
  - зовиур
  - ачих, буулгах
  - өөр төрлийн, өөр хүйсийн мал амьтдыг хольж нийлүүлэх
  - тээврийн хэрэгсэл ба багаж төхөөрөмжийн чанар, таарамж
  - температур ба чийгшилт
  - өлсөх, цангах
  - тухайн мал амьтны төрлийн онцлог шаардлага
4. Мал амьтанд тээвэрлэлтийн өмнө, тээвэрлэлтийн үед тайвшруулах эм, мэдээ алдуулагч хэрэглэхийг хориглоно.



Хавсралт 2

ЖУ-061-02

## ОРГАНИК ГАЗАР ТАРИАЛАНД ТАВИХ ШАЛГУУРУУД

### ШАЛГУУР 1. ТАРИАЛАХ УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙГ СОНГОХ

#### Үндсэн зарчим

Органик хөдөө аж ахуйд тариалах ургамлын төрөл зүйлийг сонгохдоо тухайн хөрс, цаг агаарын нөхцөлд дасан зохицох чадвар, хортон шавж, өвчинд тэсвэртэй байдлыг авч үзнэ. Тариалах үр ба материалууд бүгд органик байна.

#### Зөвлөмж

Органик газар тариалангийн тогтвортой байдал, өөрийгөө тэтгэх чадвар, биологийн олон янз байдлыг нэмэгдүүлэхийн үулд олон төрлийн ургамал, тэдгээрийн төрөл зүйлийг тариална.

Тариалахаар сонгосон төрөл зүйлүүд нь генетикийн олон янз байдлыг хадгалсан байвал зохино.

Органик газар тариаланд нийцсэн гэж тогтоогдсон төрөл зүйлүүдийг тариалахыг илүүд үзнэ.

Органик аргаар гарган авсан төрөл зүйлсийг ашиглавал зохино.

#### Шаардлага

1.1 Үр ба тариалах материалууд нь органик гэж баталгаажихын тулд бүтэн 1 үе, нэг наст ургамлын, олон наст ургамлын хувьп 2 улирал ба 12 сарын аль урт хугацаагаар органик тариалалтад хамрагдсан байвал зохино.

1.2 Органик газар тариаланд тохирох төрөл зүйл, чанарын органик үр ба тариалах материалуудыг ашиглана.

Хэрэв органик үр, ургамлын материал байхгүй бол стандартаар зөвшөөрөгдөөгүй пестицидээр боловсруулаагүй уламжлалт материалуудыг хэрэглэж болно. Стандартын байгууллага холбогдох стандартууд ба органик бус үр, ургамлын материалуудыг хэрэглэх хугацааны хязгаарлалтыг тогтооно.

Хэрэв дээрх байдлаар боловсруулаагүй үр, материал байхгүй бол баталгаажуулалтын байгууллагаас зөвшөөрсөн химиин аргаар боловсруулсан үр, ургамлын материалыг тогтоосон хугацаа, нөхцөлөөр хэрэглэж болно.

### ШАЛГУУР 2. ШИЛЖИЛТИЙН ХУГАЦАА

#### Үндсэн зарчим

Органик менежментийн тогтолцоог бий болгох, хөрсний шим тэжээлийг бүрдүүлэхэд шилжилтийн хугцаа шаардагдана.

#### Зөвлөмж

Шилжилтийн хугацааг хөрсний шим тэжээл мэдэгдэхүйц нэмэгдэж, экологийн тэнцвэрт байдал эргэн тогтох хүртэл хангалттай удаан байхаар тогтоох ёстой. Шилжилтийн

хугацааг тогтоохдоо дараах нөхцөл байдалтай зохицуулна:

- Газрыг ашигласан байдал
- Экологийн нөхцөл байдал ба түүний үр дагавар
- Тухайн аж ахуйн газар тариалан эрхлэх туршлага

Хэрэв ямар нэг хориотой материал, үйлдэл хэрэглэсэн бол шилжилтийн хугацаа нь тэдгээрийг хэрэглэснээс хойш хамгийн багадаа хэдэн сараар тогтоогдоно.

#### Шаардлага

2.1 Тариалалт эхлэхээс өмнө хамгийн багадаа 12 сарын шилжилтийн хугацаа өнгөрсний дараах жилийн бүтээгдэхүүнийг органик гэж үзнэ. Олон наст ургамлын хувьд (бэлчээр, нутыг оруулахгүй) ургац хураалтаас өмнө хамгийн багадаа хэдэн сар шаардлагатай.

- Бэлчээр, нуга ба тэндээс хураасан бүтээгдэхүүнийг органик гэж үзэхийн тулд хамгийн багадаа 12 сарын шилжилтийн хугацааг уртасгаж болно.
- Газар ашиглалтын байдал, аж ахуйн менежментийн чадавхи, байгаль орчны нөхцөл байдлаас шалтгаалж шилжилтийн хугацааг уртасгаж болно.

#### ШАЛГУУР 3. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

##### Үндсэн зарчим

Хөрс, хөрсний менежмент нь органик газар тариалангийн үндэс юм. Органик газар тариалан нь хөрсөнд тулгуурладаг тул хөрс ба хүрээлэн буй эко системийг хамгаалах, биологийн олон янз байдлыг дэмжих, хөрсийг бордох, мөн хөрс, түүний шим тэжээлийн алдагдлыг багасгах арга хэмжээ авах шаардлагатай.

##### Зөвлөмж

Тариалах ургамлын олон янз байдлыг хангахын тулд дараах арга хэмжээнүүдийг авна:

- ногоон ба шошны төрлийн ургамлууд, гүн үндэстэй ургамал зэрэг олон төрлийн ургамлыг сэлгэн тарих
- хөрсийг зохих байдлаар, жилд аль болох удаан хугацаагаар олон төрлийн ургамлын бүрхэвчтэй байлгах

#### Шаардлага

3.1 Тариалах ургамлын олон янз байдал ба тариалалтын үйл ажиллагаа нь хамгийн бага сэлгэн тариалалтад ба/буюу тариалах ургамлын төрөл зүйлд тавих шаардлагагаар тодорхойлогдоно. Хэрэв нэг наст ургамлын хувьд тариалах ургамлын төрөл зүйлийн олон янз байдлыг өөр бусад аргаар батлаагүй бол хамгийн бага сэлгэн тариалалтыг тогтооно.

Газар тариалан эрхлэгч нь хөрсний органик бодисууд, шим тэжээл, микробын үйлчлэл, хөрсний эрүүл байдлыг хамгаалах, сайжруулахын зэрэгцээ хортон шавьж, хогийн ургамал, өвчний нөлөөллийг хянах шаардлагатай.

3.2 Олон наст ургамлын хувьд, баталгаажуулалтын байгууллага нь жимсний цэцэрлэг/тариалангийн хөрсний гадаргуу ба/буюу олон янз байдал, эсвэл жимсний цэцэрлэгийн аюулгүй тариалалтын хамгийн бага стандартуудыг тогтооно.

#### ШАЛГУУР 4. ХӨРСНИЙ ҮРЖИЛ ШИМ БА БОРДОЛТ

##### Үндсэн зарчим

Органик газар тариалан нь микробын, ургамлын ба амьтны гаралтай материалыг хөрсөнд эргүүлж шингээх замаар хөрсний үржил шим, биологийн идэвхийг хадгалж,

сайжруулдаг.

Зөвлөмж

Хөрсний шим тэжээлийг нэмэгдүүлэхэд органик аж ахуйгаас гарсан микробын, ургамлын, эсвэл амьтны гаралтай, биологийн хувьд задардаг материалуудыг ашиглана.

Шим тэжээлийн эх үүсвэрүүдийг тогтвортой, хариуцлагатай ашиглах ёстай. Органик аж ахуйгаас байгальд алдагдах шим тэжээлийн алдагдлыг хамгийн бага байлгавал зохино. Шим тэжээлийн үр ашгийг хангахын тулд тэдгээрийг шаардлагатай хугацаанд, шаардлагатай газарт нь ашиглах нь зүйтэй. Хүнд металл ба бусад бохирдуулагчид хуримтлагдахаас сэргийлнэ.

Байгалийн эрдэс бордоо ба биологийн гаралтай, гарган авсан, хэрэглэхийг зөвшөөрсөн бордоог шим тэжээлийн тогтолцооны зөвхөн нэг хэсэг, үржил шимиин орлуулалт бус, нэмэгдэл гэж үзнэ.

Хэрэв хүний ялгадас бүхий бордоо хүний өвчин үүсгэгч организм (патоген) агуулсан бол ашиглаж болохгүй.

Эрүүл ахуйд онцгой анхаарах шаардлагатай ба тэдгээрийг хүн хэрэглэх ургамалд ба нэг наст ургамал тариалах хөрсөнд дараагийн 6 сард шууд хэрэглэхгүй байх нь зүйтэй.

### Шаардлага

4.1 Микробын, ургамлын ба амьтны гаралтай материалууд нь хөрсний үржил шимийг тэтгэх үндсэн бүтээгдэхүүнүүд байна.

4.2 Шим тэжээлүүд ба бордоог хэрэглэхдээ хөрс, ус, байгалийн олон янз байдлыг хамгаалахад чиглүүлнэ. Тоон хэмжээ, байрлал, цаг хугацаа, боловсруулалт, аргачлал ба сонголтоос хамаарч хэрэглээнд хязгаарлалт тогтооно.

4.3 Хүний ялгадас агуулсан бордоог хүн хэрэглэх тарианд ашиглахыг хориглоно.

Хортон шавьж, шимэгч хорхой, халдвэр үүсгэгчдээс урьдчилан сэргийлэх; хориглосон бодис агуулж байж болох ахуйн болоод үйлдвэрлэлийн хог хаягдалтай бордоог холилдуулахгүй байх талаар стандартын байгууллага эрүүл ахуйн нарийвчилсан шаардлага тогтоох тохиолдолд энэ нь хамааралгүй байж болох юм.

4.5 Удаан хугацаагаар бордох шаардлагатай үед эрдэс бордоог зөвхөн бусад арга хэрэгслүүдийн, жишээ нь, органик нэмэлтүүд, ногоон бордоо, сэлгэн тариалалт, азот шингээгч бактери г.м хамтаар хэрэглэнэ.

4.6 Байгалийн жамаар бий болсон, ялгарсан хэлбэрээр нь эрдэс бордоог хэрэглэх ба ус нэмэх, өөр бусад байгалийн гаралтай, зөвшөөрөгдсөн нэмэлтүүдтэй холихоос өөрөөр, химийн боловсруулалтаар уусгаж хайлуулж болохгүй.

4.7 Азотын хүчлийн давс ба шээсийг оролцуулан бүх нийлмэл азотын бордоог хэрэглэхийг хоригтоно.

### ШАЛГУУР 5. ХОРТОН ШАВЬЖ, ХОГИЙН УРГАМАЛ, ӨВЧЛӨЛ БА ГАЗАР ТАРИАЛАНГИЙН МЕНЕЖМЕНТ

#### Үндсэн зарчим

Органик газар тариаланд биологийн ба уламжлалт арга хэрэгслүүдийг ашиглан хортон шавьж, өвчин, хогийн ургамлаас үүдэлтэйгээр гарч болох алдагдлаас сэргийлнэ. Үүний тулд тухайн орчинд сайн дасан зохицох чадвартай ургамал, тэдгээрийн төрөл зүйлийг тариалах ба хөрсийг биологийн өндөр идэвхитэй, үржил шимтэй байлгахад чиглэсэн тэнцвэртэй бордох хөтөлбөр, сэлгэн тариалалт, дагалдах тариалалт, ногоон бордоо ба

Энэхүү стандартаар тогтоосон зөвшөөрөгдсөн органик практикийг ашиглана.  
Ургамлын өсөлт, хөгжил нь байгалийн жамаар явагдах ёстой.

### Зөвлөмж

Нэг буюу хэд хэдэн дараах арга хэмжээг хослуулан, мэдлэгтэйгээр ашиглах замаар хортон шавьж, өвчин, хогийн ургамалтай тэмцэнэ:

- Тохирох ургамал, түүний төрөл зүйлийг сонгох
- Тохирох сэлгэн тариалалт хийх
- Механик хөрс боловсруулалт хийх
- Хашаа, үүрлэх байр барих, тэдгээрийн амьдрах орчин бүхий экологийн бамбай бус байгуулах зэргээр хортон шавьжаар хооллогчдыг хамгаалах
- Эко системийн олон янз байдлыг хадгалах. Энэ нь газарзүйн байршилаас шалтгаалан янз бүр байдаг. Жишээлбэл, элэгдлийг сааруулах бамбай бус, агро-ой, сэлгэн тариалах ургамлууд, нягтуулан тариалах г.м
- Дулааны аргаар хогийн ургамлыг устгах
- Үрсэлгээ бэлтгэх
- Махчин, паразит/ шимэгч зэрэг байгалийн дайснуудыг нь тавих
- Чулуун нунтаг, аж ахуйгаас гарсан бордоо, эсвэл ургамлаас гарган авсан зөвшөөрөгдсөн био динамик бэлдмэлүүд
- Гялгар хучлагаар бүтээх, хадах;
- Урхи, тор, гэрэл, дуу чимээ, саад хориг зэрэг механик хэрэгслүүд ашиглах

### Шаардлага

5.1 Органик аж ахуй нь хортон шавьж, хогийн ургамал, өвчлөлтэй ердийн нөхцөлд тэмцэх тогтолцоог бий болгосон байна.

5.2 Хэрэв 5.1-т заасан арга хэмжээ хангалтгүй бол тухайн аж ахуйд нутгийн ургамал, амьтан, микро организмуудаар бэлтгэсэн хортон шавьж, өвчлөлт, хогийн ургамлын эсрэг бүтээгдэхүүнийг ашиглаж болно.

5.3 Хортон шавьж, хогийн ургамал, өвчлөлийн эсрэг дулааны гэх мэт физик аргуудыг ашиглаж болно. Хортон шавьж, өвчлөлийн эсрэг хөрсийг дулаанаар ариутгахыг хязгаарлана.

## ШАЛГУУР 6. БОХИРДЛООС/ХАЛДВАРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

### Үндсэн зарчим

Органик хөрс ба хүнсний бүтээгдэхүүнийг бохирдлоос хамгаалах бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

### Зөвлөмж

Газар тариалан эрхлэгч нь гарч болох бохирдлыг тогтоох, түүнээс зайлсхийх арга хэмжээ авах үүрэгтэй.

Ингэхдээ НАССР-ын (Аюулын үнэлгээ ба эрсдэлийн цэгийг тогтоох) тогтолцооны дүрэм журмуудыг хэрэгжүүлэхэд анхаарч, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг сайжруулах, бохирдлын эх үүсвэрүүдийг илрүүлэх, бохирдлын суурь түвшинг үнэлэхэд илүү анхаарал тавих нь зүйтэй.

Хүнд металл, бохирдуулагч бодисууд хуримтлагдахаас хязгаарлах холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Саад хориг, бамбай бүсийн аргыг ашиглаж органик бүтээгдэхүүн дэх бохирдуулагч бодисыг хязгаарлах, болзошгүй бохирдлоос сэргийлэх арга хэмжээ авна.

Синтетик бүтээлэг, хучлага, ноос, хялгас, шавьжны тор, даршны баглаа зэрэгт зөвхөн

полиэтилен, полипропилин эсвэл поликарбонат хэрэглэхийг зөвшөөрнө. Тэдгээрийг хэрэглэсний дараа хөрснөөс зайлуулах шаардлагатай ба тариалангийн талбайд шатааж устгахыг хориглоно.

Уламжлалт газар тариаланд ашиглаж байсан төхөөрөмжүүдийг органик аж ахуйд хэрэглэхээс өмнө сайтар цэвэрлэх шаардлагатай.



ОРГАНИК ЗӨГИЙН АЖ АХУЙ, ОРГАНИК ЗӨГИЙН БАЛАНД ТАВИХ ШАЛГУУРУУД

## ШАЛГУУР 1. НИЙТЛЭГ ЗАРЧИМ

Хэрэв зөгийн аж ахуй эрхлэгч нь хэд хэдэн зөгий үргүүлгийн газартай бол тухайн нэгж бүр нь энэ баримт бичгийн шаардлагыг хангаж байх ёстай.

## ШАЛГУУР 2. ЗӨГИЙНИЙ ГАРАЛ

Зөгий нь тухайн орчин нэхцөлд дасан зохицох, амьдрах, өвчин эсэргүүцэх чадвар сайтай байвал зохино. Нутгийн омгийн зөгийг илүүд үзнэ.

Органик зөгий үргүүлгийн газрыг шинэчлэхдээ жилд 10% хүртэл органик шаардлага хангахгүй хатан зөгийнүүд буюу бүлийг органик сархиагтай зөгийн үүрт эсвэл сархиагт шилжүүлж болно.

Өвчин, гамшгийн улмаас шалтгаалж зөгий олноор үхсэн тохиолдолд ердийн зөгийн сүргээр (органик шаардлага хангасан зөгийн сүрэг байхгүй нэхцөлд) сэлбэсэн бол органик зөгийн аж ахуйд шилжих шилжилтийн хугацааг 1 жилээр тооцно.

## ШАЛГУУР 3. ЗӨГИЙ ҮРЖҮҮЛГИЙН ГАЗРЫН БАЙРШИЛ.

Зөгий үргүүлгийн газрын байршил дараах шаардлагуудыг хангаж байх ёстай. Үүнд:

3.1 Зөгий үргүүлгийн газрын эргэн тойронд 3 км радиусын доторх цэцгийн тоос, балны эх үүсвэр нь органик газар тариалан, органик шаардлагад нийцсэн нутгийн ургамал, эсвэл органик шаардлагад хамаарахгүй боловч органик зөгий үргүүлгийн шаардлагад нөлөөлөхгүй эко газар тариалан байх,

3.2 Хот суурин газар, авто зам, аж үйлдвэр, хогийн цэг, хаягдал шатаах газар гэх мэт аливаа бохирдол гаргагч хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэлийн эх үүсвэрүүдээс хангалттай хол зайнд байх. Энэ шаардлага нь зөгий ичсэн байдалд байгаа үед хамаарахгүй.

3.3 Зөгийг цэцгийн тоос, бал, усаар хангах хангалттай нөөцтэй байх.

## ШАЛГУУР 4. БАЙРШЛЫН БҮРТГЭЛ

4.1 Зөгийн аж ахуй эрхлэгч нь зөгийн үүрнүүдийн байршил, бэлчээр, сүргийн тоо, бүтээгдэхүүний агуулах, үйлдвэрлэлийн буюу савлах байршуудыг тэмдэглэсэн тодорхой масштаб бүхий газрын зурагтай байна.

Мөн тухайн газар нутаг нь органик зөгийн аж ахуйн шаардлага хангаж буй талаар холбогдох баримт бичиг, судалгаатай байна.

4.2 Зөгийн аж ахуй эрхлэгч нь зөгийн үүрнүүдийн байршлыг өөрчилсөн бол тухай бүр тэмдэглэл хөтөлнө.

## ШАЛГУУР 5. БҮЛИЙН БҮРТГЭЛ

Зөгийн аж ахуй эрхлэгч нь бүлийн бүртгэлийг дараах байдлаар хөтлөнө. Үүнд:

- зөгийн үүрний байршил,
- бүлийн дэлгэрэнгүй танилцуулга
- байгалийн бус тэжээлийн тухай мэдээлэл
- зөгийн үүрний сархиагийг авсан, бал олборлосон мэдээлэл

## ШАЛГУУР 6. ХООЛ ТЭЖЭЭЛ

- 6.1 Үйлдвэрлэлийн улирлын төгсгөлд зөгийн үүрийг өвлийг давахад хангалттай хэмжээний цэцгийн тоос, балны нөөцтэй үлдээнэ.
- 6.2 Өвлийн нөөц хангалтгүй тохиолдолд зөгийг тэжээж болох ба органик зөгийн бал, аль болох тухайн аж ахуйгаас гаргаж авсан органик балыг тэжээлд хэрэглэнэ.
- 6.3 Тэжээлд органик зөгийн балны оронд органик чихрийн сироп, органик паста хэрэглэж болно (ялангуяа зөгийн бал талстжих цаг уурын онцгой г.м нөхцөлд).
- 6.4 Тэжээлийг хамгийн сүүлийн зөгийн бал хураалтаас дараагийн цэцгийн бал гарахаас 15 хоногийн өмнө хүртэл хугацаанд өгнө.
- 6.5 Зөгийн тэжээлийн холбогдолтой дараах мэдээллүүдийг бүртгэлд оруулсан байна.  
Үүнд: бүтээгдэхүүний нэр төрөл, огноо, тоон хэмжээ, тэжээл хэрэглэсэн үүрүүд.

## ШАЛГУУР 7. ӨВЧЛӨЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

- 7.1 Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг баримтлана. Үүнд:
  - тэсвэр хатуужилтай үүлдрийн зөгий сонгох,
  - өвчин эсэргүүцэх, халдвараас урьдчилан сэргийлэх тохиromжтой арга хэмжээг хэрэгжүүлэх;
  - бүлүүдийг байнга шинэчлэх, өвчлөлөөс сэргийлэх үзлэгийг үүрүүдэд хийж байх,
  - эр зөгийнүүдийг хянах,
  - бохирдсон материал, эх үүсвэрүүдийг заавар журмын дагуу зөв зайлцуулах,
  - зөгийн лавыг тогтмол шинэчлэх ба цэцгийн тоос, балны хангалттай нөөцийг үүрэнд байлгах г.м.
- 7.2 Урьдчилан сэргийлэх эмчилгээнд химиин аргаар синтезлэсэн аллопатик эмийн бүтээгдэхүүнүүд хэрэглэхийг хориглоно.

## ШАЛГУУР 8. ЭМЧИЛГЭЭ

- 8.1 Өвчилсөн, халдварласан булийг халдварт өвчнийг эмчлэх журмын дагуу нэн даруй эмчилгээнд хамруулах ба шаардлагатай тохиолдолд зөгий үржүүлэх газрыг тусгаарлана.
- 8.2 Зөвхөн холбогдох мэргэжлийн байгууллагаар зөвшөөрөгдсөн эм, эмчилгээний бүтээгдэхүүнийг хэрэглэх ба шоргоолжны хүчил, цууны хүчил, хурган чихний хүчил, ментол, тимол, эвкалипт ба камфорыг Varroa jacobsoni-ийг хянах зорилгоор, багасгах замаар ашиглаж болно.
- 8.3 Зөвхөн ургамлын гаралтай (питотерап) ба төрлөөр нь эмчлэх (хомеопат) эмчилгээний бүтээгдэхүүнийг өвчин, халдварыг хянахад хэрэглэж болно. Химиин аргаар синтезлэсэн аллопатик эмийн бүтээгдэхүүнийг зөвхөн шаардлагатай үед эмчийн зааврын дагуу хэрэглэнэ.
- 8.4 Эмчилгээнд химиин аргаар синтезлэсэн аллопатик эмийн бүтээгдэхүүнийг хэрэглэсэн бол эмчилгээний хугацаанд тухайн зөгийн булийг тусгаарласан газарт шилжүүлэх ба зөгийн лавыг энэ журамд заасан лаваар солих шаардлагатай.
- 8.5 Эмчилгээний ямар ч бүтээгдэхүүнийг хэрэглэсэн тохиолдолд өвчний оношийн хамтаар дараах мэдээллийг хөтөлж, бүртгэсэн байна. Үүнд:
  - эмийн бүтээгдэхүүний нэр (идэвхитэй фармаколог бодисуудыг заана),
  - хэрэглэсэн тун хэмжээ,

- хэрэглэсэн аргачлал,
- эмчилгээний хугацаа

#### ШАЛГУУР 9. ЗӨГИЙН АЖ АХУЙД БАРИМТЛАХ ДАДЛАГА/ТУРШЛАГА

9.1 Зөгийг сархиагт нь устгах замаар зөгийн аж ахуйн бүтээгдэхүүнийг авахыг хориглоно.

9.2 Хатан зөгийн далавчийг тасдах гэх мэтээр гэмтээхийг хориглоно. Харин эх зөгийг зохиомлоор хээлтүүлсэн нөхцөлд өөр булийн эр зөгийтэй нийлэхээс сэргийлж далавчийг бага хэмжээтэй тайрч тэмдэглэхийг зөвшөөрнө.

9.3 Хөгшин хатан зөгийг устгах гэх мэтээр өөр хатан зөгийгөөр сольж болно. Байгалийн үржил, нөхөн үржихүйг илүүд үзнэ. Сүрэглэх инстинктийг (терөлх зан араншин) харгалзаж үзэх нь зүйтэй.

9.4 Зохиомол үр тогтоолтыг зөвшөөрөх боловч генетикийн хувьд өөрчлөгдсөн зөгийг ашиглахыг хориглоно.

9.5 Зөгийн эр сүргийг зөвхөн шимэгчээр халдварласан *Varroa jacobsoni* өвчтэй байх шалтгаанаар устгаж болно.

9.6 Шавьж устгадаг химиийн синтетик бодисыг зөгийн бал гаргаж авах явцад хэрэглэхийг хориглоно.

9.7 Зөгийн бүтээгдэхүүнийг гаргаж авах, боловсруулах, хадгалах үйл ажиллагаанд онцгой хянамгаа хандаж, бүх үйл ажиллагаанд тэмдэглэл хөтлөнө.

#### ШАЛГУУР 10. ЗӨГИЙН ҮҮР БА ЗӨГИЙН АЖ АХУЙД ХЭРЭГЛЭХ МАТЕРИАЛУУДЫН ШИНЖ ЧАНАР

10.1 Зөгийн үүрийг хийхдээ орчныг бохирдуулахгүй, зөгийн бүтээгдэхүүнд эрсдэлгүй байгалийн материалаар голчлон хийнэ.

10.2 Өвчин, халдварыг хянах бүтээгдэхүүнүүдийг оролцуулахгүйгээр зөгийн жилий, лав, ургамлын тос зэрэг зөвхөн байгалийн гаралтай бодисуудыг үүрэнд хэрэглэнэ.

10.3 Шинэ хүрээ үүсгэх зөгийн лавыг органик зөгийн аж ахуйгаас авна.

10.4 Үр төл агуулдаг сархиагаас зөгийн бал гаргаж авахыг хориглоно.

10.5 Утаа, галын дөл гэх мэт физик эмчилгээг хамгийн бага хэмжээнд хэрэглэхийг зөвшөөрнө. Утааны материал нь байгалийн гаралтай байна.





БАТЛАВ.

.....XXK-ийн захирал

Монголын Үндэсний Худалдаа  
Аж Үйлдвэрийн Танхимын дарга

.....

..... М.ОЮУНЧИМЭГ

**"ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮН/ CERTIFIED ORGANIC" ЭКО ШОШГО  
ХЭРЭГЛЭХ, ГЭРЭЭ**

20.... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг Нэг талаас ..... XXK түүнийг төлөөлж тус компанийн  
захирал, ..... /Цаашид А тал гэх/, Нөгөө талаас MYXAYT-ын дарга М.Оюунчимэг  
/Цаашид Б тал гэх/ нар харилцан тохиролцож байгуулав.

**1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 1.1 Гэрээ нь "Organic бүтээгдэхүүн/Certified organic" эко шошго хэрэглэх хязгаар, хугацаа, боломжуудыг зохицуулна
- 1.2 Гэрээ нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг тодорхойлох ба "Organic бүтээгдэхүүн/Certified organic" эко шошго бүхий бүтээгдэхүүнийг сурталчлах, хэрэглэгчдийг төөрөгдүүлэхээс зайлсхийх, бусад нөхцөлүүдийг тодорхойлсон байна
- 1.3 Үйлдвэрлэлийн нууцад хамаарах аливаа мэдээ, баримт материалыг "Organic бүтээгдэхүүн/Certified organic" эко шошго олгохоос бусад зорилгоор ашиглахгүй байх, бусад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, хувь хүнд үл задруулж хадгалах эрх үүргийг хүлээхтэй холбогдсон харилцааг зохицуулна

**2. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 2.1 А талын эрх, үүрэг
- 2.1.1 "Organic бүтээгдэхүүн/ certified organic" эко шошго хэрэглэх эрх авсан байгууллага цаашид үйл ажиллагаагаа тогтвортжуулах, боловсронгуй болгох төлөвлөгөө гаргаж ажиллана.
- 2.1.2 Өөрийн өгсөн мэдээ мэдээллийн аль хэсэг нь Нууцад хамаарах талаар Б талын төлөөлөгчид мэдээлэх.
- 2.1.3 Б талаас Нууцад хамаарах мэдээ мэдээллийг цааш нь бусад аж ахуйн нэгж,

байгууллага, албан тушаалтан, хувь хүнд тараахгүй байхыг шаардах.  
Шаардлагыг зөрчсөн эсэх талаар магадлан шалгах эрхтэй.

## 2.2 Б талын эрх, үүрэг

- 2.2.1 "Органик бүтээгдэхүүн/ certified organic" эко шошго хэрэглэх гэрээт хугацаанд А талаас бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи, бүтээгдэхүүний итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлт, үйлдвэрлэлийн менежменттэй холбоотой асуудлаар асуулга авч хяналт тавьж ажиллана
- 2.2.2 "Органик бүтээгдэхүүн/ certified organic" эко шошго хэрэглэх эрх авсан бүтээгдэхүүнүүдийг өөрийн боломжит сувгуудаар сурталчилна
- 2.2.3 А талын үйлдвэрлэлийн талаар мэдэж авсан аливаа нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, тоон болон бусад хэлбэрээр бичигдсэн баримт материалыг үл нийцсэн зорилгоор ашиглахгүй байх. Зайлшгүй бөгөөд А талын эрх ашигт сайнаар нөлөөлөх зорилгоор ашиглахад хүрвэл А талын удирдлагын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу ашиглах.

## 3. "ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮН/ CERTIFIED ORGANIC" ЭКО ШОШГОНЫ ХЭРЭГЛЭЭ

- 3.1 "Органик бүтээгдэхүүн/ certified organic" эко шошгоны журамд заасан хугацаанд хэрэглэгдэнэ.
- 3.2 Гэрээт хугацаанд бүтээгдэхүүний орц найрлагад өөрчлөлт оруулахыг хориглох, шаардлагатай тохиолдолд Б талд албан бичгээр хандах
- 3.3 "Органик бүтээгдэхүүн/ certified organic" эко шошгыг хэрэглэх боломжууд:
  - Бүтээгдэхүүний шошго, танилцуулга, каталог, интернет хаяг, аж ахуйн нэгжийн болон сурталчилгааны танилцуулга дээр тухайн бүтээгдэхүүний зураг, тодорхойлолтын хамт байршуулах
  - Байгууллага, худалдааны төвийн үүдэнд тухайн бүтээгдэхүүний зураг, тодорхойлолтын хамт байршуулах, сурталчлах /наах, хавчих, танилцуулга хэлбэрээр/
  - Үзэсгэлэн, яармагийн үеэр тухайн бүтээгдэхүүний зураг, тодорхойлолтын хамт ашиглах
- 3.4 Дээрх үйл ажиллагаанд зөвхөн "Органик бүтээгдэхүүн" эко шошго хэрэглэх эрх авсан бүтээгдэхүүнийг сурталчлах ба аж ахуйн нэгжийг сурталчлах зорилгоор ашиглахыг хориглоно.

## 4. НУУЦАД ХАМААРАХ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

- 4.1 Дараах мэдээ мэдээлэл, баримт материал хамарагдана. Үүнд:
  - Үйлдвэрлэлийн технологи, шат дамжлагын талаарх баримт, материал, схем, бүдүүвч
  - Түүхий эд, материалын зарцуулалтын талаарх баримт, бүдүүвч, схем
  - Барилгын болон тоног төхөөрөмжийн зураг, төсөл,
  - Цахилгаан хангамжийн инженерийн шугам сүлжээний зураг
  - Дулаан, уур, ус, цэвэр бохир усны системийн шугам сүлжээний зураг

- Бүх төрлийн эдийн засгийн тооцоо, судалгаа
  - Бүтээгдэхүүний үндсэн, туслах материал норм
  - Нууцад хамаарулсан бусад мэдээ баримт
- 4.2 А тал нууцад хамаарах мэдээ баримтыг Б талд шилжүүлэхдээ урьдчилан сануулж, баримт материалын эцсийн хуудасны арын зүүн доод хэсэгт "Нууц" гэсэн тусгай тэмдэглэл үйлдэж "Гарт нь" гэж хаяглагдсан дугтуйтай явуулна.
5. БУСАД ЗҮЙЛ
- 5.1 Гэрээг бичгээр 2 хувь үйлдэж талууд хадгална.
- 5.2 Талууд харилцан тохиролцсон тохиолдолд гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт өөрчлөлт оруулна.
- 5.3 Талууд харилцан тохиролцож гэрээг цуцалж болно.
- 5.4 Гэрээнээс үүссэн маргааны талууд харилцан тохиролцож шийдвэрлэх ба 14 хоногийн дотор тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд Монгол Улсын холбогдох хуулийн дагуу, шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

А талыг төлөөлж:

.....XXK-ийн захирал

Б талыг төлөөлж:

Монголын Үндэсний Худалдаа  
Аж Үйлдвэрийн Танхимын

Хаяг:

.....

Хаяг:

УБ, Хан-Уул дүүрэг, Махатма Гандийн  
гудамж, MYXAYT-ын байр, 406 тоот



"ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮН/CERTIFIED ORGANIC" ШОШГО АВСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
ЖАГСААЛТ

№	Гэрчилгээний дугаар	Бүтээгдэхүүний нэр	Үйлдвэрлэгч	Регистрийн дугаар	Олгосон огноо